



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2026 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 91

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох, тогтоолын хавсралтад  
нэмэлт оруулах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.13, 9.15 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 10.<sup>1</sup> дүгээр зүйлийн 10.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Магадлан шалгах ажиллагааны 2026 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн дүгнэлтийн дагуу Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох хуулийн этгээд (4)-ийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч “Стар трий блүүм” ХХК-ийн гаргасан хүсэлтийн дагуу “Тусгай зөвшөөрөл олгох тухай” Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 49 дүгээр тогтоолын хавсралтын “Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж” хэсэгт “Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Орхон, Сэлэнгэ, Улаанбаатар” гэж нэмсүгэй.

3.Тусгай зөвшөөрөл шинээр олгосон хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, тусгай зөвшөөрөлд нь өөрчлөлт орсон хуулийн этгээдтэй гэрээг шинэчлэн байгуулах, зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдох өөрчлөлт оруулах арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

ДАРГА

ГИШҮҮД

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2026 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн  
91 тоот тогтоолын  
хавсралт

Тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн  
жагсаалт

| № | Хуулийн этгээдийн<br>нэр   | Хамрах хүрээ, үйлчилгээний<br>хүртээмж                                       | Тусгай<br>зөвшөөр-<br>лийн<br>хугацаа | Дуусах<br>хугацаа |
|---|----------------------------|------------------------------------------------------------------------------|---------------------------------------|-------------------|
| 1 | “Ачмаг хайрхан” ХХК        | Улс хоорондын шуудангийн<br>үйлчилгээ эрхлэх<br>/Чиглэл: Монгол Улс – БНХАУ/ | 5 жил                                 | 2031.07.09        |
| 2 | “Тэгш саруул зам”<br>ХХК   | Улс хоорондын шуудангийн<br>үйлчилгээ эрхлэх<br>/Чиглэл: Монгол Улс – БНХАУ/ | 5 жил                                 | 2031.07.09        |
| 3 | “Кор лэнд экспресс”<br>ХХК | Улс хоорондын шуудангийн<br>үйлчилгээ эрхлэх<br>/Чиглэл: Монгол Улс – БНСУ/  | 5 жил                                 | 2031.07.09        |
| 4 | “Чой энд хаку” ХХК         | Улс хоорондын шуудангийн<br>үйлчилгээ эрхлэх<br>/Чиглэл: Монгол Улс – БНСВУ/ | 5 жил                                 | 2031.07.09        |

----- оОо -----